



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Хөдөө Аж Ахуйн Их Сургууль-Эдийн засаг бизнесийн сургууль

Хөтөлбөрийн нэр: Нягтлан бодох бүртгэл

Индекс: D041101

Шинжээчийн баг:

Ахлагч: Л.Наранчимэг /МУИС-ийн БС-ийн НББ-ийн тэнхимийн эрхлэгч доктор,  
профессор/

Гишүүд: М.Уранчимэг /СнЯ-ны төрийн захиргаа удирдлагын газрын нягтлан  
бодогч/

Х.Нямбаяр /Мандах ИС-ийн НББ-ийн тэнхимийн эрхлэгч, дэд  
профессор/

Он сар өдөр: 2021.06.21

## **Агуулга**

### **Товчилсон үгийн тайлбар**

#### **I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

#### **II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга**

#### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

#### **IV. Уулзалтад оролцогчдын нэрс**

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс.

IV. Төгсөгчдийн нэрс

#### **V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**

#### **VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

#### **VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

## Товчилсон үгийн тайлбар

-

### I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Эдийн засаг бизнесийн сургууль Mongolian University of Life Sciences, School of Economics and Business	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Нягтлан бодох бүртгэл Accounting	
<b>Индекс</b>	D041101	
<b>Шинжээчид</b>	1. Л.Наранчимэг 2. М.Уранчимэг 3. Х.Нямбаяр	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Г.Даваажаргал	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b> /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу
	<u>2021-06-15</u> <u>Мягмар гараг</u>	БМИҮЗ-ийн ажлын албаны захирал О.Янжмаа үг хэлж шинжээчийн багийн хүлээлгэн өгнө
	09:00-10:00	Шинжээчийн багийн ахлагч магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулна Сургуулийн захирал үг хэлнэ. Хөтөлбөрийн товч танилцуулга
	10:00-11:00	Сургуулийн орчинтой танилцах
	11:00-13:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	13:00-14:00	Үдийн завсарлага
	14:00-16:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах
	16:30-17:00	Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
	<u>2021-06-16</u> <u>Лхагва гараг</u> <u>Цахимаар</u> 09:00-10:00	Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
	10:00-11:00	Багш нартай уулзах
	<u>11:00-12:00</u>	Оюутнуудтай уулзах

	<u>12:00-13:00</u>	Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах
	<u>13:00-14:00</u>	Үдийн завсарлага
	<u>14:00-15:00</u>	Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах
	<u>15:00-16:00</u>	Шинжээчийн багийн уулзалт, хэлэлцүүлэг
	<u>16:00-17:00</u>	Шинжээчийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 02 тоот тогтоолоор батлагдсан Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага, холбогдох дүрэм, журам, зүйн баримт бичиг	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

ХААИС ийн Нягтлан бодох бүртгэл анхны хөтөлбөр нь 1972 онд БНМАУ-ын СнЗ-ийн тогтоолоор ХАА-н дээд сургуульд ХАА-н нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн анги нээн 1973 оноос анхны элсэлт авах шийдвэр гарснаар батлагдсан. Нягтлан бодох бүртгэл нь анхны төгсөлтөө 1977 онд хийснээс хойш эдүгээ 44 дэх төгсөлтөө хийсэн бөгөөд 2021 оны байдлаар нийт 5303 мэргэжилтэн бэлтгэсэн байна. Тус хөтөлбөр нь 2005 онд дотоодын БМИҮЗ-өөр анх удаа магадлан итгэмжлэгдсэн ба 2014 онд АНУ-д төвтэй Олон улсын Бизнесийн удирдлагын магадлан итгэмжлэлийн байгууллага ACBSP -ээр тус тус магадлан итгэмжлэгдсэн. Одоо тус хөтөлбөрт 14 багш ажиллаж байна. Нийт багш нарын 36 хувь нь эрдмийн зэрэг цолтой, 62 хувь нь ахлах багш зэрэгтэй.

### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

#### **Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт**

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### **1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Боловсрол шинжлэх ухааны сайдын 2014 оны А/78 тоот тушаалаар батлагдсан “Мэргэжлийн чиглэл, индекс шинэчлэн батлах тухай”, 2014 оны А/174 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага батлах тухай”, 2014 оны А/285 тоот тушаалаар батлагдсан “Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлд заавал судлах хичээлийн батлах тухай” ХААИС-ийн бакалаврын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам зэргийг үндэслэн хөтөлбөрийг боловсруулан мөрдөж байна
- Хөтөлбөрийн STEEP шинжилгээний дүнд хөтөлбөрийн боломж, сорилт, мэргэжилтний ирээдүйг тодорхойлсон.
- Дотоодын 4, гадаадын 5 их дээд сургуулиудын сургалтын төлөвлөөний бүтцийг харьцуулан судалсан.

##### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Мэргэжилтний ур чадварын боломж, сорилт, мэргэжилтний ирээдүйг тодорхойлсон.

##### **Анхаарах асуудал:**

- Бусад ИДС-тай зөвхөн сургалтын төлөвлөгөөний бүтцийг харьцуулсан. Хөтөлбөрийн харьцуулалт гэдэг бол арай өргөн ойлголт юм.

##### **Зөвлөмж:**

Хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар нягтлан бодогчийн эрэлт хэрэгцээ байгаа, аж ахуйн нэгж байгууллагын тоо өсөж байгаа ч мэргэжилийн ирээдүйн хөгжил улам бүр цахимжиж нягтлан бодогчийн ажил үүрэг өргөн болж буй өнөөгийн нөхцөлд мэргэжлийнхээ үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлээр сургууль тэнхимээс тодорхой ажлууд санаачлан хийх нь чухал юм.

## **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

### **Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн 2019-2028 оны стратеги төлөвлөгөөний зорилтуудад тулгуурлан Хөтөлбөрийн сургалтын зорилго, зорилтуудыг тодорхойлохыг зорьсон. Хөтөлбөрийн зорилго зорилтыг сургуулийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг.
- Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрийн төгсөгчийн загварыг тодорхойлсон.
- Оролцогч талуудын хэрэгцээ шаардлага, зөвлөмж, саналыг хөтөлбөрийн зорилго, төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар хандлагад тусгасан байдлын судалгааг хийсэн.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- ХААИС-ийн 2019-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулагдан мөрдөж байгаа боловч Эдийн засаг бизнесийн сургуулийн 2011-2020 оны төлөвлөгөө, НББШ-ний тэнхимийн 2018-2027 оны стратеги төлөвлөгөөнүүд мөрдөгдөж байгаа нь хоорондоо уялдаа муутай байв.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтууд нь хэт дэлгэрэнгүй, хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн боловсролын зорилго тодорхой бус.
- Хөтөлбөрийн зорилго, зорилтуудыг тодорхойлохдоо ажил олгогч, төгсөгч, суралцагч гэх мэт оролцогч талуудын саналыг төдийлөн тусгаагүй. Тайланд энэ талаар судалгаа авдаг гэж бичсэн боловч нотлох баримт хангалтгүй байлаа.

#### **Зөвлөмж:**

- Салбар сургуулийн болон тэнхимийн стратеги төлөвлөгөөг ХААИС-ийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулж боловсруулж хэрэгжүүлэх.
- Хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн боловсролын зорилго, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг (PLO) сайжруулах, боловсруулах. Оролцогч талуудын саналыг бодитоор тусгах.

## **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн “Хөтөлбөрийн хорооны журамд”-д зааснаар хөтөлбөрийг боловсруулах, хянах, батлах үйл ажиллагааг мэргэжлийн хөтөлбөрийн хороо,

хөтөлбөрийн дэд хороо, хөтөлбөрийн ерөнхий хороогоор үе шаттайгаар хэлэлцэн шийдвэрлэдэг.

- 2017 онд батлагдсан сургалтын төлөвлөгөөг өдрийн анги мөрдөж байна. /127 багц цаг/
- Эчнээ ангийн сургалтын төлөвлөгөөг шинэчлэн 60 багц цаг болгон өөрчилсөн. /76 багц цаг байсан/
- Нягтлан бодох бүртгэл хөтөлбөрөөр төгсөгчдийн эзэмших мэдлэг, ур чадварыг ерөнхий, мэргэжлийн, мэргэшүүлэх ур чадвар гэж ангилсан
- Хөтөлбөрийн зорилт болон хичээлүүдээр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагын уялдаа холбоо нийцлийн матрицыг хийсэн.
- Хичээл бүрийн багц материалууд хийгдсэн

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Анхаарах асуудал:**

- Сургалтын төлөвлөгөөг 2017 оноос хойш шинэчлээгүй, сонгон судлах хичээлийн тоо, цаг бага байна. Тухайлбал: Мэргэшүүлэх чиглэлийн 5 хичээлийн 15 багц цагаас, 4 хичээл буюу 12 багц цагийг сонгохоор оруулсан нь сонголт мөн гэхэд эргэлзээтэй байна.
- Эчнээ ангийн сургалтын төлөвлөгөөний багц цагийг багасгахдаа оролцогч талуудын саналыг тусгаагүй.

### **Зөвлөмж:**

- Хичээлийн суралцахуйн үр дүнг (CLO) хөтөлбөрийн зорилттой уялдуулан дахин сайжруулах шаардлагатай.
- Харьцуулсан судалгаа, оролцогч талуудын санал асуулгын үндсэн дээр өдрийн ангийн сургалтын төлөвлөгөөг сайжруулах

## **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

### **Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн захирлын 2017 оны А/183 тоот тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөг мөрдөж байна

- “ХААИС-ийн бакалаврын сургалтын журам”-ын дагуу хичээлийн жил нь үндсэн 4 цикл, нэмэлт 2 циклээс бүрддэг. Үндсэн цикл 8 долоо хоног үргэлжлэх ба тухайн циклд оюутан сургалтын төлөвлөгөөнд тусгасан заавал болон сонгон суралцах хичээлүүдийг судална. Харин нэмэлт цикл 4 долоо хоног байх бөгөөд энэ циклд оюутан хичээлээ түрүүлж судлах, дүнгээ ахиулах, дахин судлах боломжтой.
- 2015 оноос удирдлагын мэдээллийн ULMS системийг шинэчлэн оюутан өөрийн сурах хуваарийг төлөвлөх, хичээл багшаа сонгох боломжтой болсон.
- Боловсролын суурь хичээл 34 кц, мэргэжлийн суурь хичээл 30к кц, мэргэшүүлэх хичээл 48, сонгон судлах хичээл 15 кц нийт 127 кц. Сонгон судлах 7 хичээлээс 5 хичээлийг сонгодог.
- Хичээлийн уялдаа холбоо хийгдсэн.
- Сургалтын дадлага, үйлдвэрлэлийн дадлага хийдэг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- Дадлагыг 6 кц аар буюу 2 удаа хийдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутан хичээл, багшаа сонгох боломж хомс. Сонгох хичээлийн тоо цөөхөн.

#### **Зөвлөмж:**

- Сургалтын төлөвлөгөөг шинэчлэн сайжруулж, оюутны сонголтыг нэмэгдүүлэх.
- Сургалтын төлөвлөгөөнд бизнесийн ёс зүй, мэргэжлийн англи хэлний хичээлүүдийг нэмж, бизнесийн эрх зүй, программ хангамжийн хичээлийн цагийг нэмэх.
- ХААИС-ийн зорилготой уялдуулан Хөдөө аж ахуйн нягтлан бодох бүртгэл хичээлийг заавал судлах хичээлд оруулах.

### **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын арга зүйг сайжруулах зорилгоор хичээлийн жилийн үндсэн цикл бүрийн эцэст оюутнудаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг.
- Сургалтад уламжлалт болон орчин үеийн олон арга зүйг ашигладаг.
- Цахим сургалтыг Google classroom программ ашиглан явуулж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**



- Цахим сургалтыг сайн зохион байгуулдаг. Google classroom программ ашиглан багш лекц, семинар, бие даалтын бүхий л материалуудыг оюутанд хүргэж чадаж байна.

**Зөвлөмж:**

- Сургалтын шинэлэг арга зүйг нэвтрүүлэх.
- Кейсийн сантай болох

**2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Бакалаврын журмын дагуу оюутны мэдлэг, чадвар, хандлагыг дүгнэх үнэлгээний стандарт, нийтлэг шаардлага, тоон болон үсгэн үнэлгээ, үнэлгээний голч оноо зэргийг тусган үнэлдэг.
- Хөтөлбөрт тусгагдсан хичээл бүрийн үнэлгээ: Явцын үнэлгээ 70 хувь /шууд үнэлгээ буюу онолын мэдлэгийг үнэлэх 30 оноо, шууд бус үнэлгээ хандлага 10 оноо, бие даалт мэргэжлийн ур чадвар 30 оноо/. Хөндлөнгийн үнэлгээ 30 хувь
- Сүүлийн 5 жилийн дунджаар боловсролын суурь хичээлийн голч үнэлгээ 2.8, мэргэжлийн суурь хичээлийнх 2.6, мэргэшүүлэх хичээлийн голч үнэлгээ 2.9 байна

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны үнэлгээнд хандлагын үнэлгээг 10 хувиар үнэлдэг

**Анхаарах асуудал:**

- Мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл бүрийн үнэлгээнд шинжилгээ хийж хангалтгүй судалсан оюутнуудын шалтгааныг тодруулж арга хэмжээ авч байх

**Зөвлөмж:**

- Тест, сорилын санг улам бүр баяжуулах
- Хөндлөнгийн үнэлгээг тухайн тестийн сангаас сонгон авдаг байх

**2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### 3.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

##### Илрэл нотолгоо:

- Хичээлийн байр, сургалтын анги танхим, лаборатори, цахим хичээлийн материал боловсруулах иж бүрэн тоноглогдсон сургалтын студи, цахим сургалтын танхим, багаар ажиллах танхимын хүрэлцээ, хангамж, ашиглалтын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн, хийсэн ажлын тайлан.
- Сургалтын тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, цахим орчны ашиглалт, хүртээмж, сэтгэл ханамжийн судалгаа

#### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

##### Онцлог зүйл/Туршлага:

- Сургалт явуулах анги танхим, лаборатори, багшийн ажиллах орчин зэрэг нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлага хангасан байна гэж үзэж байна.
- Хөтөлбөрийн сургалтад танхим ба цахим хосолсон сургалт (blended e-learning)-ыг 2014 оноос эхлэн нэвтрүүлэн ажиллаж байгаа ба үүнтэй холбоотойгоор сургуулийн интернэт орчин, мэдээллийн технологийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг байнга шинэчлэн, сайжруулсан.
- Европын Холбооны ЭРАСМУС ПЛЮС хөтөлбөрийн хүрээнд 2018-2020 онд хэрэгжсэн “Хүнс, ХАА-н салбарын дээд боловсролд цахим сургалтыг нэвтрүүлэх” төслийн хүрээнд цахим хичээлийн материал боловсруулах иж бүрэн тоноглогдсон сургалтын студи, цахим сургалтын тэнхим, цахим уулзалтын өрөөг тус тус тохижуулсан.
- Сургалтын орчны сэтгэл ханамжийн судалгааг тогтмол хийж хэвшсэн бөгөөд судалгааны үр дүн болон оюутнуудын сэтгэл ханамж өндөр байна.
- Оюутан цахим орчинд бие даан ажиллах орчин нөхцөлийг жилээс жилд тогтмол сайжруулсаар ирсэн ба MULS-WiFi орчин бүрдүүлсэн.
- Сургуулийн эргэн тойрон ногоон бүсээр хүрээлэгдсэн эко орчин бүрдүүлсэн.

##### Анхаарах асуудал:

- Багш нар хувийн зөөврийн компьютер ашигладаг.

- Дотуур байрны эрүүл ахуйн стандартын шаардлагыг хангаж, урсгал засварыг ажлыг сайжруулах

**Зөвлөмж:**

- Компьютер техник хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, цахим орчны ашиглалт, хүртээмжийг сайжруулах

**3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын хэрэглэгдэхүүн, нөөцийн жагсаалт, хүртээмж, ашиглалт, сэтгэл ханамжийн судалгаа
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмж
- Багш нар google.classroom платформыг ашиглан сургалтыг явуулдаг.
- E-контент түвшинд 100 хувь боловсруулсан сургалтын материал

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Компьютерын лаборатори, интерактив сургалтын төвд мэргэжлийн хичээлүүдийн сүүлийн үеийн программуудыг ( ERP -нягтлан бодох бүртгэл, удирдлагын программ, Google G Suite, R программ, Rural invest Riv5.0[1], Moodle, Camtasia 2020, SPSS 20, Интерактив Diamond, DIAMOND ERP 5.0, EvIEWS 7, BandiCAM) ашиглаж байна.
- Сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулахад нийт 243.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

**3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрөөр суралцагсад 1,793 төрлийн 8,710 ном, сурах бичгийг ЭЗБС-ийн номын сангаас авч үйлчлүүлэх боломжтой бөгөөд эдгээрийн 50.3 хувийг эх хэлээрээ, 49.7 хувийг гадаад хэлээр ашиглах боломжтой.
- 1 оюутанд ногдох сурах ном сурах бичгийн хүрэлцээ маш өндөр,/ стандарт нь 20 байхаас 79,5 байгаа нь +59,5-р илүү/
- Мэргэжлийн ном сурах бичгийн баяжилт 9,5 хувиар өссөн үзүүлэлттэй.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

## Онцлог зүйл/Туршлага:

- Номын санд цөөн хувьтай болон эрэлт ихтэй ном, судалгааны ажлуудыг электрон каталогт оруулан цахимаар унших боломжийг бүрдүүлсэн. 300 гаруй ном, 170 ширхэг судалгааны ажлыг сканердаж PDF файл болгон <https://muls.lib4u.net/> электрон каталогт байршуулсан.
- Компакт дискээс 332 ш магистрын ажил, 75 ш диссертац, 135 ш бакалаврын ажлыг хуулж электрон каталогт холбосон. Springer мэдээллийн сангаас англи хэл дээрх 200 ш номыг татан авч электрон каталогт оруулж хэрэглэгчдийн хүртээл болгосон.
- Мэргэжлийн тэнхимийн багш нар бие даан болон хамтран туурвисан ном сурах бичиг, эрдэм шинжилгээний бүтээл гаргаж зохиогчийн эрхийн гэрчилгээгээр баталгаажуулан сургалтад ашигладаг.
- Үүлэн технологи дээр суурилсан Lib4u Version шинэ хувилбар болон “Online library management system” программыг төв болон салбар номын сангуудад ашиглаж байна.
- 2018 оноос Монгол Улсын Үндэсний Номын сан, ХААИС ХАА-н төв номын сантай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. ХААИС-ийн багш, судлаач, суралцагчид дараах цахим мэдээллийн сангуудыг ашиглах боломжтой.
- ХААИС-ийн интернэт сүлжээнээс:
  - <http://search.ebscohost.com>, <https://link.springer.com/>
  - <http://search.ebscohost>.
- Гадна орчноос :
  - <http://ebsco.cc/muls>
  - <https://www.research4life.org/>
  - <http://www.fao.org/agera/en/>
  - <http://www.wipo.int/ard/en/>
  - <http://oare.research4life.org/content/en/journals>
  - <http://goali.ilo.org/content/en/journals>.

## Зөвлөмж:

- Цахим номын баяжилтыг нэмэгдүүлэх

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: **Бүрэн хангасан**

## Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж, хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

## **Илрэл нотолгоо:**

Удирдлагын шуурхай, оновчтой үйл ажиллагааг хангахад чиглэсэн, мэдээлэл цуглуулах, боловсруулах удирдлагын мэдээллийн тогтолцоог бүрдүүлсэн нь дараах системүүдээс харагдаж байна.

- ХААИС-ийн цахим: <https://muls.edu.mn/>
- Сургалтын удирдлагын мэдээллийн систем: ISLS систем
- Санхүүгийн программ: <https://www.unicus.mn/nar/>
- Багшийн хөгжил программ: <https://lce.muls.edu.mn/login.php>
- Элсэлтийн цахим: <https://elselt.muls.edu.mn/>
- Номын сан: <https://library.muls.edu.mn/> ; <https://muls.lib4u.net/>

Сургалтын чанарыг сайжруулах, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангахад чиглэсэн дараах дүрэм, журмуудыг мөрдөн ажилладаг байна.

- ХААИС-ийн профессор багш ажиллуулах журам
- ХААИС-ийн бакалаврын хөтөлбөр, сургалтын төлөвлөгөө боловсруулах журам
- ХААИС-ийн бакалаврын сургалтын журам
- ХААИС-ийн хөтөлбөрийн хорооны журам
- Цахим сургалтын журам
- Гадаадын иргэнийг суралцуулах журам
- Бакалаврын сургалтын гэрээ
- Бакалаврын оюутны эрдэм шинжилгээний ажлын журам
- Номын сангийн үйлчилгээний дотоод журам
- ХААИС-ийн оюутны байрны дотоод журам
- ХААИС-ийн оюутны ёс зүйн дүрэм

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь хөтөлбөрийн шинэчлэлд мэргэжлийн чиглэлийн төрийн болон төрийн бус байгууллагууд, ажил олгогч, төгсөгчдийн санал, ирээдүйн хандлагыг тусгаж ажилладаг нь дараах зүйлсээс харагдаж байна.

- ХААИС-ийн ЭЗБС-ийн НББ хөтөлбөрийн хорооны хурлын тэмдэглэлүүд
- 2015-2021 оны тэнхимийн хурлын тэмдэглэлүүд
- Тэнхимийн жилийн төлөвлөгөө, тайлангууд
- Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Тэнхим нь магистр, докторын хөтөлбөрийн хороо, Бакалаврын хөтөлбөрийн хороотой. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой 10 гаруй дотоод журам байна. Эдгээрийн 90 гаруй хувь нь 2015 оноос хойш шинэчлэгдсэн. Бакалаврын хөтөлбөрийн хороо нь дээд боловсролын шинэчлэл болон зах зээлийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан хөтөлбөрийг сайжруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх ажлыг хийж ирсэн байна.

- НББ хөтөлбөрийг мэргэжлийн хөтөлбөрийн хороо боловсруулж мэргэжлийн хөтөлбөрийн хороо, бүрэлдэхүүн сургуулийн хөтөлбөрийн хороо, ерөнхий хөтөлбөрийн хороо гэсэн дарааллаар үе шаттайгаар хэлэлцүүлдэг.
- Дотоод нөөц бололцоогоо ашиглан ISLS системийг хөгжүүлж байгаа.
- ХААИС-ийн 2019-2028, ЭЗБС-ийн 2011-2020, НББШТ-ийн 2018-2027 оны стратеги төлөвлөгөөтэй.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөр шинээр батлуулах, өөрчлөлт оруулах, оролцогч талуудын хүсэл, шаардлага хүлээн авах, шийдвэрлэх үйл явц хоцрогдсон, боловсронгуй бус, оролцогч талуудаас авсан судалгааны үр дүн, жилийн болон улирлын тайланд дүн шинжилгээ хийж, ахиц дэвшлийг тухай бүрд дүгнэдэггүй харагдаж байна.

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр шинээр батлуулах, өөрчлөлт оруулах, оролцогч талуудын хүсэл, шаардлага хүлээн авах үйл явцыг сайжруулах, боловсронгуй болгох.

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож, багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ЭЗБС нь 16 орны 33 их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээтэй. НББШТ нь 2015-2020 оны хичээлийн жилүүдэд Япон улс, БНХАУ, БНЧУ, Унгар улс, Польш улс, ОХУ-ын их дээд сургуулиудтай хамтын ажиллагаатай ажиллаж, багш болон оюутан солилцооны хөтөлбөр, оюутнуудын сургалтын дадлага хийх, зочин профессороор ажиллах, хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах, хамтарсан судалгаа хийх зэрэг олон талаар хамтран ажилладаг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нар НББ, Аудит, Татварын чиглэлээр төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг.
- Мөн мэргэжлийн сургалтуудыг ХАА, уул уурхай, мал эмнэлгийн салбар болон төсвийн байгууллагын нягтлан бодогч нарт зохион байгуулж 2016-2020 оны хооронд нийтдээ 43 удаагийн сургалтад нийт 1255 иргэнийг хамруулсан байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Гадаадын 13 их дээд сургууль, байгууллага, Дотоодын 20 орчим их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг.
- НББШТ нь UNDP, дэлхийн банк, Мерси Кор зэрэг гаднын байгууллагууд болон мэргэжлийн төрийн бус байгууллага, их дээд сургуулиудтай хамтарч ажилладаг. ӨМӨЗО-ы Багшийн их сургуультай 2+2 хөтөлбөр, ОХУ-ын Эрхүүгийн ХААИС-тай 3+1 зэрэг хөтөлбөр хэрэгжүүлдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Төгсөгчдийн холбоо нь төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авдаг ба төгсөгчидтэй хамтран спортын арга хэмжээ зохион байгуулдаг боловч төгсөгчдөд зориулсан сургалт, семинар зохион байгуулах, тасралтгүй хөгжүүлэх тал дээр хангалтгүй ажиллаж байна.

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг эрчимчүүлж сайжруулах, сурталчилах
- Төгсөгчдөд давтан сургалт зохион байгуулах зэрэг тасралтгүй боловсролын системийг хөгжүүлэх

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн санхүүгийн үйл ажиллагаа нь Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, НББ-ийн тухай, Төрийн албаны тухай, Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Шилэн дансны тухай зэрэг бусад холбогдох хууль, дүрэм, журам, ХААИС-ийн санхүүгийн үйл ажиллагааны журам, ЭЗБС-ийн санхүүгийн үйл ажиллагааны журам болон их сургуулийн удирдах зөвлөлөөр баталсан тухайн жилийн төсвийн хүрээнд хэрэгждэг байна.
- НББ хөтөлбөрөөр суралцагчдын өдөр болон эчнээ ангийн сургалтын төлбөр нь ЭЗБС-ийн сургалтын төлбөрт эзлэх хувьд шинжилгээ хийж үзэхэд хөтөлбөрийн орлого нь нийт бүрэлдэхүүн сургуулийн орлогын 32-39 хувийг 2015-2020 онуудад эзэлж байна.
- НББ-ийн хөтөлбөрөөр суралцаж байгаа нэг оюутанд ногдох зардал 2016 онд 2,095,000 төгрөг, 2017 онд 2,411,000 төгрөг, 2018 онд 3,010,000 төгрөг, 2019 онд 2,996,000 төгрөг, 2020 онд 2,840,000 төгрөг байсан байна.

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан.**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэсэн, шинэчлэлт өөрчлөлтөд зориулж жил бүрийн төсөвт хөрөнгө оруулалт, эрдэм шинжилгээ судалгааны ажил, багш нарын мэргэжил дээшлүүлэх зардлуудыг төсөвлөж, зарцуулдаг. 2015-2020 онд нийт зардлын 6.2 хувийг (дундажаар) хөтөлбөрийн сайжруулалттай холбоотой зарцуулсан байна.

**Анхаарах асуудал:**

- Тэнхим болон хөтөлбөр бие даасан санхүүгийн эрх мэдэлгүй, хууль зүйн хувьд хязгаарлагдмал шинжтэй.
- Тэнхим сургалтын төлбөрийн орлогоос бусад төрлийн орлогын эх үүсвэргүй байна.
- ХААИС-ийн хэмжээний нийт зардлыг бүрэн шингээх аргаар дундажлан тооцдог.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн өртөг зардлын тооцооллыг боловсронгуй болгох.
- Төсөл, хөтөлбөр, сургалт, судалгааны ажил зэрэг олон эх үүсвэрээс санхүүжих боломжийг судлан төлөвлөж, хэрэгжүүлэх.

**4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн хэмжээнд мэргэжил сурталчлах, ЕБС төгсөгчдийн мэргэжил сонголт, мэргэжлийн чиг баримжаа олгох, улмаар элсэгчдийн тоог тогтвортой хадгалж, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангах үүднээс маркетингийн хөтөлбөр болон маркетингийн төлөвлөгөөг боловсруулан ажилладаг байна.
- “ХААИС-ийн элч оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлж, 33 элч оюутан сургууль, сурч буй мэргэжлээ сурталчлан таниулах, ЕБС-ийн сурагчдад болон эцэг эхчүүдэд мэргэжлийн чиг баримжаа олгоход туслан, хөдөө орон нутагт амжилттай ажиллаж 1630 оюутан элсэн суралцсаны 35.9 хувь буюу 599 оюутан ЭЗБС-д элссэн ба тэдний 26 хувь нь НББ хөтөлбөрийг сонгон суралцсан байна.
- Элсэгч, эцэг эх болон олон нийтэд зориулсан 20 төрлийн маркетингийн сурталчилгааны үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.****Онцлог зүйл/Туршлага:**

- “ХААИС-ийн элч оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлж хөдөө орон нутгаас оюутан элсүүлэх ажил зохион байгуулдаг.



- “ХАА-н салбарын хөгжил ба хүний нөөцийн хангамжийг нэмэгдүүлэх” төслийг боловсруулж хэрэгжүүлсэн байна.
- Гадаад хэл дээр олон нийтэд зориулсан маркетингийн үйл ажиллагаа явуулдаг.

#### **Анхаарах асуудал:**

- НББ-ийн мэргэжлийг сурталчлах, НББ-ийн хөтөлбөрийн элсэгчдэд зориулсан тусгайлсан үйл ажиллагаа хангалтгүй явагдаж байна.

#### **Зөвлөмж:**

- НББ-ийн мэргэжлийг сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулах, НББ-ийн хөтөлбөрийн элсэгчдэд зориулсан сурталчилгааны ажлыг өргөжүүлэх

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Үндсэн цахим хуудаснаас салбарлан тэнхим цэснээс тэнхимийн танилцуулга, түүхэн замнал, тэнхимээс заадаг хичээлүүд болон тэнхимийн бакалавр, магистр, докторын хөтөлбөрийн индекс, НББ-ийн хөтөлбөр зэргийг харах боломжтой байдаг. ЭЗБС-ийн НББШТ-ийн холбоосоор мэдээлэл хийдэг байна.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагаанд зориулан сурах бичиг, монограф, гарын авлага боловсруулан олны хүртээл болгодог бөгөөд сүүлийн 5 жилд нийтдээ 21 ном сурах бичиг, монограф, 23 гарын авлага туурвиж, 16 ном гарын авлага редакторлаж олны хүртээл болгосон байна.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын үйл ажиллагаанд зориулан сурах бичиг, монограф, гарын авлага, боловсруулан олны хүртээл болгодог.

#### **Анхаарах асуудал:**

- Тэнхим, хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар сүүлийн үеийн шинэ мэдээллийг тухай бүр хүргэхэд анхаарах хэрэгтэй.

#### **Зөвлөмж:**

- Тэнхим, хөтөлбөрийн шинэ мэдээллийг тухай бүрд олон сувгаар түгээж байх

**4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шалгуурыг бүрэн хангасан.**

## **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Тус хөтөлбөрт элсэгчид ХААИС-ийн “Бакалаврын сургалтын журам”-аар элсэн суралцах харилцааг зохицуулдаг. Жил бүр шинээр элсэгчдийн тушаалыг гаргаж баталгаажуулдаг
- Зөвлөх багш нар шинээр элсэгч оюутныг тухайн мэргэжлийн 1-р ангид элсэхэд намрын улирлын 0 долоо хоногт хүлээн авч зөвлөгөөг өгдөг.
- Элсэлтийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр болон [www.muls.edu.mn](http://www.muls.edu.mn), [www.elselt.edu.mn](http://www.elselt.edu.mn) веб цахим хуудсаар дамжуулан элсүүлдэг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ХААИС, бүрэлдэхүүн сургуулиас оюутанд зориулсан оюутны гарын авлагыг жил бүр шинэчлэн боловсруулж, элсэгчидээ гарын авлагаар бүрэн хангадаг.
- ХААИС нь жил бүрийн элсэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүрэм, журамд нийцүүлэн МИДСК-тай хамтран зохион байгуулдаг.
- Элсэгчдийн босго оноог БШУЯ-ны сайдын тушаалын хүрээнд ХААИС-ийн бакалаврын сургалтын журамд үндэслэн тогтоодог.
- Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба нь шинээр элсэн суралцагчийг ULMS программд бүртгэснээр түүнтэй холбоотой харилцаа үүсдэг.
- Тус хөтөлбөрөөр суралцан төгссөн гадаад 17 оюутны 7 оюутан нь магистрын сургалтанд үргэлжлүүлэн суралцаж байна.

#### **Зөвлөмж:**

- Бакалаврын сургалтын гадаад оюутны тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарах

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийг 2010-2020 онд хөгжүүлэх “ХААН КАМПУС” хөтөлбөр, “ХААИС-ийг 2016-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-тэй
- Оюутан суралцагчдын бие даан хөгжих, амьдрах, суралцах таатай орчныг бүрдүүлэх “Оюутны хөгжил хөтөлбөр”,
- “ХААН кампус” хотхон, “Экологийн цэвэр орчин” “Гэрэлтүүлэг-1” зэрэг дэд хөтөлбөртэй.
- Оюутанд үйлчлэх “Оюутны хөгжил төв”, “Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв”-ийг ажиллуулдаг.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Зөвлөн туслах үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, тэдгээртэй холбоотой тайлан гаргаж, дүн шинжилгээ тогтмол хийдэг.
- Сэтгэл ханамжийн судалгаа авч, тайлан гаргаж, түүнтэй холбоотой ажлын төлөвлөгөө гаргаж ажилладаг.
- Олимпиад АСТ, уралдаан, тэмцээнд оюутнуудыг удирдаж оролцуулдаг.
- ЭЗБУС дээр 30 дугуйлан ажиллаж, оюутнуудад нээлттэй хичээллэдэг.
- Оюутныг хөдөлмөр эрхлэлт, цагийн ажилд зуучлах зорилготой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байгуулагдан ажилладаг.
- Периодын системд шилжсэнтэй холбоотойгоор сургалтын төлбөрийг тусгай нөхцөлтэйгөөр төлдөг болсон.

### **Зөвлөмж:**

- Өөрийгөө илэрхийлэх чадвар, Санаа бодлоо ойлгуулах чадвар, бие даах ур чадваруудыг клуб дугуйлан болон зөвлөх үйлчилгээгээр олгох боломжийг нэмэгдүүлэх

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшуулал**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- ХАА-н үйл ажиллагаа явуулдаг ААН-д тусалж, нийгмийн тустай хөдөлмөрт оролцсон.
- Тэнхимийн явган аяллын хүрээнд Баянзүрхийн гүүрнээс Хар усан тохой хүртэл Туул голын эрэг хавийн хогийг цэвэрлэсэн.
- Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Хорооны эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Цус судлалын үндэсний төвтэй хамтран ажиллаж 150 оюутан цусаа хандивласан.

- Их, дээд сургуулиудын “Эерэг тэмүүлэл, мэдлэгтэй оюутан” аяны хэсгийн ахлагчаар тус сургуулиас оюутан сонгогдон ажиллаж байна.
- Тамхигүй сургууль аянд хамрагдсан.
- Ид шидийн уут 2019, Мөрөөдөлийн дэлгүүрийн үйл ажиллагаа, Ид шидийн орон 2, Ид шидтэй ах эгч, Лантуу хүүгийн богц 2020 гэсэн үйл ажиллагаанд оролцсон.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- ХААИС-ийн захирлын нэрэмжит батламж олгодог. Жил ирэх тусам батламж авсан оюутны тоо нэмэгдсэн.
- Бүрэлдэхүүн сургууль нь хөтөлбөр бүрээс 1 оюутныг “Шилдгийн шилдэг” оюутнаар шалгаруулдаг ба тус хөтөлбөрөөр суралцагч 1 оюутан шалгарсан.
- Шилдэг оюутан нь төрөл бүрийн тэтгэлэгт хамрагдах, хамтын ажиллагаатай сургуулиудад хос хөтөлбөрөөр суралцах, тусгай мэргэжлийн болон хэлний сургалтад хамрагдах боломж бүрддэг.
- Шилдэг төгсөгч оюутан нь магистрантурт хөнгөлөлттэй нөхцөлөөр элсэх, бүрэлдэхүүн сургууль болон харьяа эрдэм шинжилгээний байгууллагуудад эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллах давуу эрхтэй байдаг.
- НББ-ийн улсын олимпиадад багаараа гол төлөв IV,V байр, Татварын улсын олимпиадад Тусгай байр, хувь оюутны амжилтаараа Top-10т орсон амжилттай.
- МУ-ын засгийн газар, орон нутгийн захиргааны, ААН байгууллага, олон улсын болон төрийн бус байгууллагын тэтгэлгийг 20 орчим оюутан сурлага хөдөлмөр, амжилт бүтээлээр тэргүүлэн авсан.

#### **Зөвлөмж:**

- Оюутны байгууллага, клубийн арга хэмжээнд зарцуулах төсвийг нэмэгдүүлж үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломжийг хангаж өгөх

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн суралцагчийн шилжих хөдөлгөөнийг “ХААИС-ийн бакалаврын сургалт үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 5-д заасны дагуу зохицуулдаг..
- Оюутны шилжилт хөдөлгөөний сүүлийн 5 жилийн судалгаанаас харахад сургуулиас өөрийн хүсэлтээр 103 оюутан гарч, 69 оюутан шилжиж ирсэн байна.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- Элссэн суралцаж буй суралцагчдыг тасралтгүй суралцуулах, үлдээх, жилийн чөлөө авахгүй төгсгөх үйл ажиллагааны хүрээнд ЭЗБС-ийн сургалтын алба, тэнхимийн үйл ажиллагааны хүрээнд оюутныг хөгжүүлэх, тулгамдаж буй асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэх, сургалтын уян хатан төлбөрийн нөхцөлөөр ханган ажиллаж байна.

### Анхаарах асуудал:

- Жил бүрийн эцэст шилжилт хөдөлгөөний тайлан гаргаж, шилжих болсон шалтгааныг тодруулж авч хэлэлцдэг байх.

### 5.5. Төгсөлтийн баримт бичиг

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

### Илрэл нотолгоо:

- Төгсөлтийг “ХААИС-ийн нэгдсэн хуанли”-д заасан хугацаа, сургалтын төлөвлөгөө, явцын графикийг харгалзан зохион байгуулдаг.
- ХААИС-ийн захирлын тушаалаар төгссөн, мэргэжил, боловсролын зэрэг, түүнийг гэрчлэх төгсөлтийн бичиг баримтыг үндэслэн диплом, энгэрийн тэмдэг олгодог.

## Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

### Онцлог зүйл/Туршлага:

- ULMS системээс дипломыг хэвлэдэг.
- Бакалаврын диплом бичилтийг монгол (кирилл ба уйгуржин), англи хэлээр бичиж хэвлэн гаргадаг.
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн магадлан итгэмжлэлийн байгууллага болох ACBSP -ийн тамга, тэмдгээр баталгаажсан.

### Анхаарах асуудал:

- Оюутнууд дипломын ажил бичих, хамгаалах боломжийг нэмэгдүүлэх тал дээр анхаарах

### Зөвлөмж:

- Суралцагч оюутны төгсөлтийн үйл ажиллагааны өмнө явагдах дүн тулгалтын ажлыг системээр шийддэг байх

## 5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

### Шалгуур 6. Багшлах бүрэлдэхүүн

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийн багш нарын 36 хувь буюу 5 багш докторын зэрэгтэй, үлдсэн 9 багш нь магистрын зэрэгтэй, 7 багш докторантурт сурч байна. Багш нарын зэрэглэлийн хувьд дэд профессор 2, ахлах багш 6, багш 4, дадлагажигч багш 2 байна.
- ХААИС-ийн НББШТ-ийн багшлах бүрэлдэхүүн нь дараах шаардлага, баримт бичиг, журмын шаардлагыг хангаж ажилладаг байна. Үүнд:
  - БСШУС-ын Сайдын 2020.05.29-ны өдрийн А/270 тоот тушаалаар баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага”
  - ХААИС-ийн дүрэм
  - ХААИС-ийн хөдөлмөрийн дотоод журам
  - ХААИС-ийн профессор багш ажиллуулах журам
  - ХААИС-ийн багшийн ёс зүйн дүрэм
  - ХААИС-ийн ажиллагсдын ёс зүйн дүрэм
  - ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам
  - ХААИС-ийн шилдэг тэнхим шалгаруулах журам
  - ХААИС-ийн профессор, дэд профессор олгох журам
  - ХААИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
  - ХААИС-ийн санхүүгийн журам
  - ЭЗБС-ийн санхүүгийн журам
- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөөнд “Судлаач, багш нарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх тухай (2019-2028)”-ний стратеги зорилт дэвшүүлсэн.
- Дүрэм журмын хүрээнд урамшуулал олгохоос гадна гадаад, дотоод сургалт, эрдэм шинжилгээний хуралд оролцох үйл ажиллагааг дэмждэг байна.

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Багшлах бүрэлдэхүүний хувьд АССА, МНБ зэрэг мэргэжлийн байгууллагын сургалтанд хамрагдсан, мэргэжлийн зэрэгтэй, мэргэжлийн шалгалтуудаа өгч буй багшлах бүрэлдэхүүнтэй.
- Холбогдох дүрэм журмууд ХААИС-ийн веб сайтад нээлттэй байршсан.

#### **Анхаарах асуудал:**

- Багшийн цагийн ачаалал нормоосоо 2 дахин өндөр байна. Сүүлийн 3 жилийн дунджаар 1 багшид ногдох оюутны тоо 40 байна.

#### **Зөвлөмж:**

- Хичээлийн цагийн төлөвлөлтийг харгалзан багшийн тоог нэмэгдүүлж, цагийн ачааллыг бууруулахад анхаарах.

### **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- ХААИС-ийн зүгээс багшийн хөгжлийг дараах чиглэлүүдээр дэмжин ажилладаг байна. Үүнд:
  - Багшийн хөгжил хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж байна.
  - ХААИС нь багшийн хөгжлийн төв байгуулсан.
  - Сургуулийн дотоод хэрэгцээнд зориулан багшийн хөгжлийн программыг хөгжүүлсэн.
  - 2018 оноос багшийн чадамжийг үнэлж, сурган заах арга зүй, судалгааны арга зүйн чиглэлийн 20 орчим сургалтуудыг зохион байгуулсан.
  - Дүрэм журмын хүрээнд урамшуулал олгохоос гадна гадаад, дотоод сургалт, эрдэм шинжилгээний хуралд оролцох үйл ажиллагааг дэмждэг
  - Хамтын ажиллагаатай гадаадын их сургуулиудад болон дотоодод докторантурт суралцуулах гэх мэт ажлууд байна.
- Багшийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн дараах баримт бичгүүдийг боловсруулан мөрддөг байна. Үүнд:
  - ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөө 2019-2028
  - Багшийн хөгжлийн хөтөлбөр
  - ХААИС-ийн профессор багшийн хөгжил, чадамжийг үнэлэх журам
  - ХААИС-ийн Хөдөлмөрийн дотоод журам
  - ХААИС-ийн санхүүгийн журам
  - ЭЗБС-ийн санхүүгийн журам

- НББШТ-ийн тайлан

## **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- ХААИС-ийн хөгжлийн стратеги төлөвлөгөөнд “Судлаач, багш нарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх тухай (2019-2028)”-ний стратеги зорилт дэвшүүлсэн.
- Багшийн хөгжлийн хөтөлбөрийн баримт бичигтэй.
- Багшийн хөгжлийн төв нь профессор багш нараас сургалтын эрэлт, хэрэгцээний судалгаа авч, багшийг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын төсөл хөтөлбөрүүдтэй хамтран ажиллах, сургалт зохион байгуулах чиглэлээр ажилладаг.
- Багшийн хөгжлийн программтай.
- Багш нар жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө, мэргэжил боловсролоо дээшлүүлэх, сургалтын үйл ажиллагаа, мэдээллийн технологийн мэдлэгээ харилцан солилцох зорилт тусган ажилладаг.

### **Анхаарах асуудал:**

- Багш нарыг Монгол Улсад болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн зэргийг авахад бодлогоор дэмжлэг үзүүлэх, тасралтгүй байдлыг хангах
- Багшийн хөгжлийн программ нь багшийн үнэлгээ, санал асуулгыг тусгасан байдаг ба цаашид хөгжүүлэх шаардлагатай.

### **Зөвлөмж:**

- Дотоодын болон олон улсын холбоод, нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөр бүхий бусад сургуулийн багш нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох
- Багшийн хөгжлийн программыг хөгжүүлэх, видео, цахим хичээл, сургалтын сан бүрдүүлэх, бусад системүүдтэй уялдаатай ажиллах
- Багшийн хөгжил хөтөлбөрийн цаашдын хэрэгжилт, зохион байгуулалт, хяналт, үнэлгээнд улам илүү анхаарч ажиллах

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Тэнхимийн багш нар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, хөтөлбөр, ном сурах бичгийн сайжруулалтыг хийж ирсэн байна. Үүнд:
  - Тэнхимийн багш нар 2016 оноос хойш бие даан болон хамтран туурвисан сургалт, эрдэм шинжилгээний 7 бүтээлд зохиогчийн эрхийн гэрчилгээг авч хичээл, сургалтын



үйл ажиллагаанд ашиглаж байгаа бөгөөд ном, сурах бичгийн агуулгыг тасралтгүй шинэчилж, засварлаж, баяжуулдаг.

- Тэнхимийн багш нар 2016-2020 онд нийтдээ шинжлэх ухааны 6, олон улсын 5 төсөл, 23 захиалгат болон гэрээт ажлыг хийж гүйцэтгэн үйлдвэрлэлд 1 ажил нэвтрүүлсэн байна.
- 2015-2020 онд нийтдээ 76 бүтээл нийтлүүлсний 87 хувийг эрдэм шинжилгээний өгүүлэл, 13 хувийг сурталчилгааны өгүүлэл эзэлж байна. Үүнээс ЭШ-ний өгүүллийн 65 хувь нь ISBN индекстэй буюу дотоодын сэтгүүлд, 35 хувь нь ISSN индекстэй буюу гадаадын хянан магадалгаа бүхий сэтгүүлд хэвлэгдсэн байна
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж ирсэн нь дараах зүйлсээс харагдаж байна. Үүнд:
  - НББШТ-ийн тайлан
  - Багш нарын зохиогчийн эрх авсан бүтээл
  - Хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, захиалгат ажлууд
  - Нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Тэнхимийн багш нар бие даан болон хамтран сургалт, эрдэм шинжилгээний бүтээл туурвидаг, ном, сурах бичгийн агуулгыг тасралтгүй шинэчилж, засварлаж, баяжуулдаг.
- Сургалт, эрдэм шинжилгээний ажлын төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу багш нарын хичээлийг циклээр хуваарилж эрдэм шинжилгээний ажилд цаг гаргах нөхцөл бололцоог бүрдүүлж ажилладаг.
- Төсөлт ажлуудад оролцдог.
- Судалгаа, эрдэм шинжилгээний ажилд зориулсан төсөв батлан ажилладаг.

#### **Анхаарах асуудал:**

- Багш нарын эрдэм шинжилгээний ажилд зарцуулах зардлын төсөв бага, олон улсад зэрэглэл өндөртэй сэтгүүлд өгүүлэл нийтлүүлэх шаардлагатай.
- Багш нарын цагийн ачаалал, нэг багшид ногдох оюутны тоо их байгаагаас багшийн судалгаа, эрдэм шинжилгээний ажил орхигдох талтай.

#### **Зөвлөмж:**

- Багш нарын эрдэм шинжилгээний ажлыг идэвхжүүлэх зорилгоор хөтөлбөрийн орлогын тодорхой хувийг хөтөлбөрийн эрдэм шинжилгээний ажилд зарцуулах, Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд багш судлаачдын бүтээлийг хэвлүүлэх тал дээр багш нарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар холбогдох дүрэм, журамд тодорхой тусгах

- Цаашид гадаадын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийг өргөжүүлэх, олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд судалгааны ажлаа нийтлүүлэх тоог нэмэгдүүлэх.

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Багш бүр хичээлийн жилийн эхэнд батлуулсан ажлын төлөвлөгөөний дагуу ажиллан хичээлийн жилийн эцэст өөрийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний талаар өөрийн үнэлгээний тайланг бичиж, бүрэлдэхүүн сургуулийн удирдлага, тэнхимийн багш нарын хурлаар танилцуулж, үр дүнг хэлэлцүүлж батлуулдаг.
- Багш нар өөрийн үнэлгээний тайлангийн хэрэгжилтэд үндэслэн дүгнэлт хийн тэнхимийн эрхлэгчтэй зөвлөлдөн дараагийн жилд гүйцэтгэлийг сайжруулах болон бүрэн гүйцэтгэх талаар цаг хугацаатайгаар тусгадаг нь дараах зүйлсээс харагдаж байна. Үүнд:
  - НББШТ-ийн тайлан
  - Багшийн төлөвлөгөө, өөрийн үнэлгээний тайлан
  - Багшийн хавтас
  - ХААИС-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээний журам
  - СБЗА, Сургалтын албаны цахим хичээлд хийсэн үнэлгээ
  - Оюутны сэтгэл ханамжийн судалгаа /2016-2021 он/

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан.**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- PDCA зарчмаар төлөвлөлт, тайлагналын үйл ажиллагаа явагддаг. Багш нар өөрийн үнэлгээний тайлангийн хэрэгжилтэд үндэслэн тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн, гүйцэтгээгүй буюу дутуу гүйцэтгэсэн ажлууддаа дүгнэлт хийн шалтгааныг нь тодорхойлж, тэнхимийн эрхлэгчтэй зөвлөлдөн дараагийн жилд гүйцэтгэлийг сайжруулах болон бүрэн гүйцэтгэх талаар цаг хугацаатайгаар тусгадаг.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм журмуудын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхдээ тоон болон чанарын үнэлгээнүүдийг ашигладаг.

#### **Анхаарах асуудал:**

- Багш нар шинэ ажил санаачлах, хэрэгжүүлэх боломж хомс, үнэлэх боломжгүй.

- Тэнхимийн төлөвлөгөө, багшийн төлөвлөгөө, тайлангийн бүтэц, үзүүлэлтүүд ялгаатай, хариуцлагын тогтолцоо сул байна.

**Зөвлөмж:**

- Төлөвлөгөө, тайлан гаргах, төлөвлөгөөний биелэлтийг хянах үйл ажиллагааг боловсронгуй болгох, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.
- Эрхэм зорилго, стратегийн зорилтууд, алба нэгжүүд, хичээлийн багуудын төлөвлөгөө хэрхэн биелэгдэж байгааг тухай бүр хянах боломжтой Dashboard гэх мэтийг ашиглах

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Шалгуурыг бүрэн хангасан.**

### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

**Илрэл нотолгоо:**

-Сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хяналт хийх, үр дүнд шинжилгээ хийж сайжруулах гэсэн дэс дараалал бүхий чанарын менежментийн PDCA арга зүйгээр хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг хийж ирсэн.

-Хөтөлбөрийг боловсруулах, өөрчлөх, сайжруулах, хяналт үнэлгээ хийхэд захирлын 2015 оны А/377 тоот тушаалаар батлагдсан хөтөлбөрийн хорооны журам, хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтын журмыг мөрддөг.

-Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалтыг “Чанарын удирдлага, зохицуулалтын алба” хариуцдаг.

-Чанарын менежментийн “зургаан сигма” тогтолцоог хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Анхаарах асуудал:**

- Чанарын зохицуулалтын албын хөтөлбөр нэгжүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх

**Зөвлөмж:**

- Сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг шинэчлэх, төгсөгчдийн давтан сургалтын талаар анхаарч ажиллах

- Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог тогтмолжуулах

## **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

### **Илрэл нотолгоо:**

-Тус хөтөлбөрийн төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин сүүлийн 5 жилийн дунджаар 92 хувь байна

-Ажил эрхэлж буй төгсөгчдийн 10 хувь нь шийдвэр гаргах түвшний албан тушаал хашиж, төгсөгчдийн 18 орчим хувь нь ахисан түвшинд үргэлжлүүлэн суралцаж байна.

-Төгсөгчдийн 12 орчим хувь нь дадлага хийсэн байгууллагадаа ажилдаа орсон байна.Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртэл дунджаар 4 сар.

-2017 оны судалгаагаар Оюутны сэтгэл ханамж 3,68-3,91, багшийн сэтгэл ханамж 4, төгсөгчдийн сэтгэл ханамж 3.57-3.72, ажил олгогчдын сэтгэл ханамж 3.89 байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Анхаарах асуудал:**

- Оролцогч талуудын судалгааг тогтмолжуулж, тасралтгүй үйл ажиллагааг үргэлжлүүлэх

### **Зөвлөмж:**

- Төгсөгчдийн эргэх холбоо ялангуяа мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах

## **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

-Тус хөтөлбөр нь БМИҮЗ-өөр 2005 онд, ACBSP байгууллагаар 2014 онд тус тус магадлан итгэмжлэгдсэн

-1977 оноос хойш 5303 мэргэжилтэн бэлтгэн гаргасан

-Төгсөгчид нь Мандах ИС-ийг үүсгэн байгуулсан. ММНБИ, НББ-ийн хүрээлэн зэрэг мэргэжлийн чиглэлийн үндэсний төрийн бус байгууллага, дэлхийн том аудитын байгууллага болох Делойт, БДО-ийн Монгол дахь албан ёсны салбарын удирдах партнер эрхтэй үүсгэн байгуулагчид байна.

-Мэргэжлийн төрийн ба төрийн бус байгууллагуудтай сургалт , олимпиад тэмцээн хамтран зохион байгуулах, ЭШХ зохион байгуулах, заавар зөвлөмж хамтран боловсруулах чиглэлээр хамтран ажиллаж байна.

-Сүүлийн 5 жилд төгсөгчдийн 18 хувь нь ахисан түвшинд үргэлжлүүлэн суралцсан. Төгсөгчдөөс 3 хүн докторын зэрэг хамгаалсан.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдийн карьер өсөлт сайтай

#### **Зөвлөмж:**

•Төгсөгчдийн эргэх холбоог сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг дэс дараатай хэрэгжүүлэх

## ДҮГНЭЛТ

### ХААИС-ЭЗБС “Нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөр” D041101

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаа г үй	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			
2	Сургалтын үйл ажиллагаа	3			
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөөц	3			
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	4	1		
5	Суралцагчид чиглэсэн үйлчилгээ	5			
6	Багшлах бүрэлдэхүүн	4			
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			
Дүгнэлт		Бүрэн хангасан			

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ХААИС сургуулийн ЭЗБС сургуулийн “Нягтлан бодох бүртгэл” хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “**ШАЛГУУРЫГ БҮРЭН ХАНГАСАН**” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Бизнес, удирдлагын чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагч: Л.Наранчимэг

Шинжээчийн багийн гишүүн: Х.Нямбаяр

Шинжээчийн багийн гишүүн: М.Уранчимэг

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

<b>Сургуулийн нэр</b>	ХААИС-Эдийн засаг бизнесийн сургууль
<b>Хөтөлбөрийн нэр</b>	Нягтлан бодох бүртгэл
<b>Хөтөлбөрийн индекс</b>	D041101
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>• Хөдөлмөрийн зах зээлийн судалгаагаар нягтлан бодогчийн эрэлт хэрэгцээ байгаа, аж ахуйн нэгж байгууллагын тоо өсөж байгаа ч мэргэжлийн ирээдүйн хөгжил улам бүр цахимжиж нягтлан бодогчийн ажил үүрэг өргөн болж буй өнөөгийн нөхцөлд мэргэжлийнхээ үнэ цэнийг нэмэгдүүлэх чиглэлээр сургууль тэнхимээс тодорхой ажлууд санаачлан хийх;</li> <li>• Салбар сургуулийн болон тэнхимийн стратеги төлөвлөгөөг ХААИС-ийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулж боловсруулж хэрэгжүүлэх;</li> <li>• Хөтөлбөрийн зорилго, хөтөлбөрийн боловсролын зорилго, хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг (PLO) сайжруулах, боловсруулах. Оролцогч талуудын саналыг бодитоор тусгах;</li> <li>• Хичээлийн суралцахуйн үр дүнг (CLO) хөтөлбөрийн зорилттой уялдуулан дахин сайжруулах;</li> <li>• Харьцуулсан судалгаа, оролцогч талуудын санал асуулгын үндсэн дээр өдрийн ангийн сургалтын төлөвлөгөөг сайжруулах;</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>• Сургалтын төлөвлөгөөг шинэчлэн сайжруулж, оюутны сонголтыг нэмэгдүүлэх;</li> <li>• Сургалтын төлөвлөгөөнд бизнесийн ёс зүй, мэргэжлийн англи хэл хичээлүүдийг нэмж, бизнесийн эрх зүй, программ хангамжийн хичээлийн цагийг нэмэх;</li> <li>• Сургалтын шинэлэг арга зүйг нэвтрүүлэх;</li> <li>• Кейсийн сантай болох;</li> <li>• Тест, сорилын санг улам бүр баяжуулах;</li> <li>• Хөндлөнгийн үнэлгээг тухайн тестийн сангаас сонгон авдаг байх;</li> <li>• ХААИС-ийнн стратегийн зорилттой уялдуулан “Хөдөө аж ахуйн нягтлан бодох бүртгэл”-ийн хичээлийг заавал судлах хичээлд оруулах. Салбарын бүртгэл хичээлийг сургалтын төлөвлөгөөнд нэмж оруулах;</li> </ul>

<p>Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Компьютер техник хэрэгслийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, цахим орчны ашиглалт, хүртээмжийг сайжруулах;</li> <li>• Цахим номын баяжилтыг нэмэгдүүлэх;</li> </ul>
<p>Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хөтөлбөр шинээр батлуулах, өөрчлөлт оруулах, оролцогч талуудын хүсэл, шаардлага хүлээн авах үйл явцыг сайжруулах, боловсронгуй болгох;</li> <li>• Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг эрчимжүүлж сайжруулах, сурталчлах;</li> <li>• Төгсөгчдөд давтан сургалт зохион байгуулах зэрэг тасралтгүй боловсролын системийг хөгжүүлэх;</li> <li>• Хөтөлбөрийн өртөг зардлын тооцооллыг боловсронгуй болгох;</li> <li>• Төсөл, хөтөлбөр, сургалт, судалгааны ажил зэрэг олон эх үүсвэрээс санхүүжих боломжийг судлан төлөвлөж, хэрэгжүүлэх;</li> <li>• НББ-ийн мэргэжлийг сурталчлах үйл ажиллагаа зохион байгуулах, НББ-ийн хөтөлбөрийн элсэгчдэд зориулсан сурталчилгааны ажлыг өргөжүүлэх;</li> <li>• Тэнхим, хөтөлбөрийн шинэ мэдээллийг тухай бүрд олон сувгаар түгээж байх;</li> </ul>
<p>Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Бакалаврын сургалтын гадаад оюутны тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарах;</li> <li>• Өөрийгөө илэрхийлэх чадвар, Санаа бодлоо ойлгуулах чадвар, бие даах ур чадваруудыг клуб дугуйлан болон зөвлөх үйлчилгээгээр олгох боломжийг нэмэгдүүлэх;</li> <li>• Оюутны байгууллага, клубийн арга хэмжээнд зарцуулах төсвийг нэмэгдүүлж үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломжийг хангаж өгөх;</li> <li>• Суралцагч оюутны төгсөлтийн үйл ажиллагааны өмнө явагдах дүн тулгалтын ажлыг системээр шийддэг байх;</li> </ul>
<p>Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хичээлийн цагийн төлөвлөлтийг харгалзан багшийн тоог нэмэгдүүлж, цагийн ачааллыг бууруулахад анхаарах;</li> <li>• Дотоодын болон олон улсын холбоод, нягтлан бодох бүртгэлийн хөтөлбөр бүхий бусад сургуулийн багш нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх, туршлага солилцох;</li> <li>• Багшийн хөгжлийн программыг хөгжүүлэх, видео, цахим хичээл, сургалтын сан бүрдүүлэх, бусад системтэй уялдаатай ажиллах;</li> <li>• Багшийн хөгжил хөтөлбөрийн цаашдын хэрэгжилт, зохион байгуулалт, хяналт, үнэлгээнд улам илүү анхаарч ажиллах;</li> <li>• Багш нарын эрдэм шинжилгээний ажлыг идэвхжүүлэх зорилгоор хөтөлбөрийн орлогын тодорхой хувийг хөтөлбөрийн эрдэм шинжилгээний ажилд зарцуулах. Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд багш</li> </ul>



	<p>судлаачдын бүтээлийг хэвлүүлэх тал дээр багш нарт санхүүгийн дэмжлэг үзүүлэх талаар холбогдох дүрэм, журамд тодорхой тусгах;</p> <ul style="list-style-type: none"> <li>• Цаашид гадаадын хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрийг өргөжүүлэх, олон улсын нэр хүнд бүхий сэтгүүлд судалгааны ажлаа нийтлүүлэх тоог нэмэгдүүлэх;</li> <li>• Төлөвлөгөө, тайлан гаргах, төлөвлөгөөний биелэлтийг хянах үйл ажиллагааг боловсронгуй болгох, уялдаа холбоог сайжруулах;</li> <li>• Эрхэм зорилго, стратегийн зорилтууд, алба нэгжүүд, хичээлийн багуудын төлөвлөгөө хэрхэн биелэгдэж байгааг тухай бүр хянах боломжтой Dashboard гэх мэтийг ашиглах;</li> </ul>
Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	<ul style="list-style-type: none"> <li>• Сэтгэл ханамжийн судалгааны асуулгыг шинэчлэх, төгсөгчдийн давтан сургалтын талаар анхаарч ажиллах;</li> <li>• Чанарын дотоод баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог тогтмолжуулах;</li> <li>• Төгсөгчдийн эргэх холбоо ялангуяа мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулах;</li> </ul>
<b>ШААРДЛАГА</b>	
Шалгуур 4.3 Санхүүжилт	<ul style="list-style-type: none"> <li>• Тэнхим болон хөтөлбөр бие даасан санхүүгийн эрх мэдэлгүй, сургалтын төлбөрийн орлогоос бусад төрлийн орлогын эх үүсвэргүй байна. Иймээс үр дүнд үндэслэн орлогын тодорхой хувиар тухайн хөтөлбөрийг урамшуулах санхүүгийн хөшүүргийг бий болгох, мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн хувьд санхүүгийн олон эх үүсвэрийг бүрдүүлэх төлөвлөгөө гарган ажиллах;</li> <li>• ХААИС-ийн хэмжээний нийт зардлыг бүрэн шингээх аргаар дундажлан тооцож байгаа нь хөтөлбөрийн нэг суралцагчид ногдох өртөг, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгжийн үр дүнг үнэн зөв илэрхийлж чадахгүй байна. Хөтөлбөрийн өртөг зардлын тооцооллыг боловсронгуй болгох;</li> </ul>

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

№	Нэр	Албан тушаал	Зэрэг цол	Ажиллас ан жил	Заадаг хичээл
1	Б.Одончимэг	Нягтлан бодох бүртгэл шинжилгээний тэнхимийн эрхлэгч	Доктор, дэд профессор	16	Дунд шатны нягтлан бодох бүртгэл – 3

2	С.Алтанцэцэг	Эрдэмтэн нарийн бичгийн дарга	Доктор, дэд профессор	26	Ахисан түвшний нягтлан бодох бүртгэл
3	С.Оюунчимэг	Ахлах багш	Магистр	25	Өртгийн бүртгэл -1, 2
4	Б.Хишигдаваа	Ахлах багш	Доктор	20	Өртгийн удирдлага -1, Бүртгэлийн мэдээллийн систем
5	Л.Батцэнгэл	Ахлах багш	Магистр	22	Татварын бүртгэл, тайлагнал
6	Я.Нансалмаа	Ахлах багш	Магистр	20	Нягтлан бодох бүртгэлийн үндэс, Өртгийн бүртгэл 1,2
7	Ч.Даваасүрэн	Багш	Магистр	17	Бизнесийн шинжилгээ, ХАА-н нягтлан бодох бүртгэл
8	Л.Ундаргаа	Ахлах багш	Доктор	8	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Хөрөнгийн үнэлгээ
9	Г.Ундрах	Багш	Магистр	15	Аудит, Нягтлан бодох бүртгэлийн үндэс
10	Э.Рэгзэндорж	Дагалдан багш	Магистр	2	Дунд шатны нягтлан бодох бүртгэл
11	Т.Болор-Эрдэнэ	Дагалдан багш	Магистр	13	Нягтлан бодох бүртгэлийн үндэс, Дунд шатны нягтлан бодох бүртгэл-2, Дунд шатны нягтлан бодох бүртгэл-1
12	Г.Нарангэрэл	Багш	Магистр	15	Нягтлан бодох бүртгэлийн үндэс, Өртгийн удирдлага-1
13	О.Дуламрагчаа	Багш	Магистр	16	Нягтлан бодох бүртгэлийн үндэс, Өртгийн бүртгэл-1
14	Ж.Баттулга	Ахлах багш	Доктор	17	Макро эдийн засаг
15	З.Эрдэнэчимэг	Ахлах багш	Доктор	19	Газар тариалангийн үндэс
16	Б.Ариунболд	Багш	Магистр	8	Санхүүгийн менежмент-1, Санхүүгийн мэдээллийн систем, Санхүүгийн эрсдэлийн менежмент
17	Ж.Бат-Өлзий	Ахлах багш	Доктор	20	Санхүүгийн менежмент-1, 2
18	О.Балжин	Багш	Магистр	15	Санхүүгийн үндэс
19	Б.Ичинхорлоо	Ахлах багш	Доктор	24	Менежментийн үндэс
20	Д.Цэвээннамжил	Ахлах багш	Доктор	21	Статистикийн онол, Магадлалын онол-математик статистик -1,2
21	Г.Энх-Амгалан	Багш	Магистр	13	Эконометрик, Хөдөө аж ахуйн статистик
22	Ч.Батжаргал	Ахлах багш	Магистр	23	Статистик мэдээлэл боловсруулалт
23	Д.Туул	Дагалдан багш	Магистр	3	Маркетингийн үндэс

24	Г.Энхманлай	Ахлах багш	Доктор	11	Мал аж ахуйн технологийн үндэс
25	Д.Кадирбек	Ахлах багш	Магистр	20	Үйлдвэрлэл, үйл ажиллагааны менежмент
26	О.Амартүвшин	Багш	Магистр		Эдийн засгийн шугаман загвар
27	Ш.Дэнсмаа	Ахлах багш	Магистр	24	Микро эдийн засагч
28	Б.Тунгалаг	Багш	Магистр		Монголын түүх, соёл,
29	Д.Оргил	Ахлах багш	Доктор	15	Мэдээллийн технологи, систем
	Д.Мөнгөнцэцэг	Ахлах багш	Магистр	13	
30	М.Мөнхзул	Ахлах багш	Доктор	16	Сэтгэлгээний түүх соёл
31	Т.Азбаяр	Багш	Магистр	22	Эдийн засгийн онол
32	М.Мөнгөнзул	Багш	Магистр	7	Англи хэл-2
33	Ч.Хулан	Дэд профессор	Доктор	25	Монгол хэл бичиг, найруулга зүй
34	Х.Сүнжидмаа	Багш	Магистр	7	Англи хэл-1
35	Б.Батзориг	Багш	Магистр	16	Биеийн тамир, эрүүл ахуй
36	Г.Туяагэрэл	Дэд профессор	Доктор		Хүний хөгжил харилцааны ёс зүй, эрх зүй
37	Ж.Анхбаяр	Багш	Магистр		Математик 1, 2
38	Д.Эрдэнэбаатар	Ахлах багш	Магистр		Гамшгаас хамгаалах менежмент

## II. Оюутны нэрс

№	Оюутны нэрс	Курс	Сонгосон байдал
1	Я.Ариунсанаа	II	Голч 3.9, Улаанбаатар, ХУД
2	Б.Ганзаяа	II	Голч 3.8, Орон нутгийн оюутан
3	Б.Дэлгэрмаа	II	Орон нутгийн оюутан, Увс Улаангом
4	Б.Дэчмаа	II	Нийгмийн идэвхтэй, орон нутгийн оюутан
5	Сайнжаргал	III	Орон нутгийн оюутан
6	Оюунчимэг	III	Орон нутгийн оюутан, Хөвсгөл, Мөрөн
7	Эрдэнэчимэг	III	Орон нутгийн оюутан
8	Энхжин	III	Орон нутгийн оюутан
9	Б.Ариунсүвд	III	Голч 3.9, Улаанбаатар, БЗД
10	Б.Хулан	III	Спортлог, Сэлэнгэ Сайхан
11	Мөнгөнтулга	III	Оюутны байранд амьдардаг. Төв, Зуунмод

12	Санчир	III	Оюутны байранд амьдардаг
13	Цэнгүүнболд	III	Оюутны байранд амьдардаг. Өмнөговь, Цогтцэций
14	Б.Ганбаатар	IV	Хэнтий аймаг Бор-Өндөр сум JCI mentorship program 2020- mentii, JCI mongol Сонирхогч гишүүн, Dale carnegie mongolia- High impact graduates 2020 Passion club-Тэргүүн
15	М.Ундармаа	IV	Завхан аймаг, Лантуун дохио ТББ-н сайн дурын гишүүн
16	Т.Хонгорзул	IV	Голч 3.7, Өвөрхангай аймаг Арвайхээр сум
17	Б.Үүрийнцолмон	IV	Голч 3.8, Улаанбаатар
18	Д.Заяадэлгэр	I	Орон нутгийн оюутан, Хөвсгөл, Мөрөн
19	Р.Төлөби	II	Орон нутгийн оюутан, Сэлэнгэ, Мандал
20	Д.Сувданчимэг	II	Сайн дурын байгууллагын гишүүн, Хөвсгөл, Мөрөн
21	Ч.Цогтбаяр	I	Хөгжлийн бэрхшээлтэй
22	Б.Дашпүрэв	IV	Оюутны зөвлөлийн гишүүн, Улаанбаатар

### III. Ажил олгогчдын нэрс

№	Овог нэрс	Байгууллага	Албан тушаал
1	Баянмөнх	БДО аудит	Ерөнхий захирал
2	Дарамбазар	Manage Wall	Захирал
3	Энхжаргал	City aliant	Гүйцэтгэх захирал
4	Магсаржав	Цогц гал ХХК	Захирал
5	Дарьсүрэн	Bulid and Technology	Ахлах нягтлан
6	Цэвэлмаа	Грант Торнтон Аудит	Захиргаа, санхүү газрын захирал
7	Амарбат	Бласт ХХК	Ерөнхий нягтлан бодогч
8	Энхтуяа	HLBMongolia-Аудит	Захирал
9	Батжаргал	Бүртгэл хөгжүүлэх сан	Тэргүүн
10	Одноо	Green group	Ахлах нягтлан
11	Эхбаяр	Эс Жи Эм Ди Аудит	Захирал
12	Даваадорж	Монголын төмөр зам	Ерөнхий нягтлан бодогч

### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Ч.Намхай	2016	Би Си Ти ХХК	Нягтлан бодогч
2	Сэр-Од Нанжидмаа	2016	Хаан банк ХХК	Харилцагчийн зөвлөх
3	Пүрвээ Одончимэг1	2017	Эйшин органик импорт ХХК	Тооцооны нягтлан бодогч
4	Баатар Бигэрмаа	2017	Тани Форa солюшн ХХК	Ерөнхий нягтлан бодогч
5	Бямаацэрэн Ганжолоо	2017	Барилга хөгжлийн төв	Нягтлан бодогч
6	Баярбат Энхмандах	2017	Цоодол дистирбушн ХХК	Борлуулалтын нягтлан бодогч
7	Дарьсүрэн Нүүдэл	2018	Хурд интернешнил ХХК	Нягтлан бодогч
8	Л.Нямжаргал	2018	БӨТА ХХК	Тооцооны нягтлан бодогч
9	Erdenebayan Urangoо	2018	Хөх чонын хийморь ХХК	Huviagaа
10	Хануй Эрдэнэтуяа	2018	hibox ХХК	Ерөнхий Нягтлан
11	Б. Мичидмаа	2019	Номин холдинг ХХК	Тооцооны нябо
12	ganzorig javzanragchaa	2019	Номин холдинг ХХК	systemiin chanar batalgaajuulagch
13	Хишигдамдин	2019	Магнай трейд ХХК	Нягтлан бодогч
14	Т. Мандахнаран	2019	Үүр тел ХХК	Нягтлан бодогч
15	Р.Хулан	2020	Green group ХХК	Орлогын нягтлан бодогч
16	Гэрэлзаяа	2020	Бизнесийн академи	Багш
17	Ж. Нандин-Эрдэнэ	2020	БДО аудит ХХК	Аудитор
18	О.Энхбаяр	2020	Монголыг төмөр зам ТӨХК	Нягтлан бодогч

## V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

/албан бичгийг оруулах/



**ХӨДӨӨ АЖ АХУЙН ИХ СУРГУУЛЬ  
ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН  
СУРГУУЛЬ**

17024 Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,  
11 дүгээр хороо, Зайсан 5, Утас: 7510 7777 252, 253  
И-мэйл: info\_seb@uls.edu.mn  
Вэб сайт: www.uls.edu.mn

2021-06-25 № 01/150  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

Шинжээчдийн дүгнэлтэд  
хариу хүргүүлэх тухай

Нягтлан бодох бүртгэл, шинжилгээний тэнхимийн "Нягтлан бодох бүртгэл" /D041101/ бакалаврын сургалтын хөтөлбөр нь Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлагыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэхээр хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланг хүргүүлсэн билээ. Үүний дагуу хөндлөнгийн шинжээчид 2021 оны 06 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд өөрийн үнэлгээний багийн гишүүдтэй хамтран ажиллаж, шалгуур тус бүрийн нотлох баримттай танилцан ажилласан.

Шинжээчийн тайлан 2021 оны 06 дугаар сарын 24-нд хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багт ирснийг хүлээн авч, уншиж танилцлаа.

Бид "Нягтлан бодох бүртгэл" бакалаврын сургалтын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайланд тусгасан зөвлөмж, дүгнэлтийг хүлээн авч, цаашид хэрэгжүүлэн ажиллах болно.

Зөвлөмж өгч хамтран ажилласан БМИҮЗ-ийн ажлын албаны дарга доктор, профессор О.Янжмаа, шинжээчдийн багийн ахлагч доктор, профессор Л.Наранчимэг, багийн гишүүд М.Уранчимэг, дэд профессор Х.Нямбаяр болон зохицуулагч доктор, дэд профессор Г.Даваажаргал нарт талархлаа илэрхийлье.

ЗАХИРАЛ \_\_\_\_\_ Б.БААСАНСҮХ



**ҮІ. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр**

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

**ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр**

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

<b>Магадлан итгэмжлэх эсэх</b>	<b>Магадлан итгэмжлэл олгох хугацаа</b>

**Зөвлөмж /Recommendations/**